



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/178/НА-СТА-ТШЗ

Цахим www.audit.mn Баруун-Урт сум 2023 он	хуудас:	Дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518396 Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123 Аудитор: О.Барчидгүнсэн Утас: 70512123
--	---------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	12
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Материаллаг байдал	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	13
5.1 Зөвлөмж	13
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТХО	Улсын Төсвийн Хөрөнгө Орвчлалт
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМД	Эрүүл мэндийн даатгал

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

С.Б. О.О. № *79*

танай _____-ны № _____-Т

СҮХБААТАР АЙМГИЙН УЛАМЖЛАЛТ
АНАГААХ УХААНЫ НЭГДСЭН
ЭМНЭЛГИЙН ДАРГА Ц.ХҮРЭЛБААТАР
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс 2022 онд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нэг иргэнд ногдох зардлын хэмжээг шинэчлэн тогтоож, үр дүн, гүйцэтгэлээр нь санхүүжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг нь эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон санхүүжилтийн 58,504.1 мянган төгрөг зарцуулагдаагүй, харилцах дансанд үлдэгдлээр үлдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Сүхбаатар аймгийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн 2022 оны 5 дугаар сард "Эмнэлгийн мэргэжлийн үйл ажиллагаа" явуулах тусгай зөвшөөрөл авч, хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд болсон байна.

D:/Bichig hereg/2023/A4 toot

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	110,965,712.03
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	58,504,177.16
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	58,504,177.16
3121	Төгрөг	-	58,504,177.16
31211	Төрийн сангийн харилцах	-	58,504,177.16
35	БАРАА МАТЕРИАЛ	-	52,461,534.87
351	Түүхий эд материал	-	43,239,419.00
35130	Эм боох материал	-	43,239,419.00
354	Хангамжийн материал	-	9,222,115.87
35410	Бичиг хэргийн материал	-	369,000.00
35420	Аж ахуйн материал	-	5,604,825.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	757,000.00
35440	Түлш, шатах тослох материал	-	77,000.00
35450	Барилгын засварын материал	-	57,300.00
35460	Хүнсний материал	-	2,180,990.87
35470	Бусад хангамжийн материал	-	176,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	67,859,163.15
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	67,859,163.15
392	Биет хөрөнгө	-	66,113,538.15
39201	Барилга, байгууламж, орон сууц	-	38,379,423.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(255,862.82)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	-	8,115,450.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	(845,755.18)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	-	16,473,336.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-	(290,275.77)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	4,614,125.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(76,902.08)
393	Биет бус хөрөнгө	-	1,745,625.00
39301	Програм хангамж	-	1,995,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(249,375.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	-	178,824,875.18
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	178,824,875.18
51	Засгийн газрын хувь оролцоо	-	178,824,875.18
512	Хуримтлагдсан үр дүн	-	178,824,875.18
51220	Тайлант үеийн үр дүн	-	178,824,875.18
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	-	178,824,875.18

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	-	442,962,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	125,618,250.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	125,618,250.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	125,618,250.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	18,850,250.00

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,518,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	104,250,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	317,343,950.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	317,343,950.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	317,343,950.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	264,137,332.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	264,137,332.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	262,898,332.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	144,323,890.09
210101	Үндсэн цалин	-	107,780,706.95
210102	Нэмэгдэл	-	14,261,163.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	5,825,995.17
210104	Урамшуулал	-	16,456,024.43
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	18,131,501.66
210201	Тэтгэврийн даатгал	-	13,413,600.54
210202	Тэтгэмжийн даатгал	-	1,242,792.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	990,873.67
210204	Ажилгүйдлийн даатгал	-	225,839.65
210205	Эрүүл мэндийн даатгал	-	2,258,395.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	32,249,205.09
210301	Гэрэл, цахилгаан	-	1,971,310.09
210302	Түлш, халаалт	-	26,663,175.00
210303	Цэвэр, бохир ус	-	3,614,720.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	10,116,730.97
210401	Бичиг хэрэг	-	1,399,300.00
210402	Тээвэр, шатахуун	-	3,195,790.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	31,350.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	953,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	4,536,790.97
2105	Нормативт зардал	-	44,109,504.16
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	21,921,594.00
210502	Хоол, хүнс	-	20,977,910.16
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,210,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	3,300,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	48,750.00
210604	Урсгал засвар	-	3,251,350.00
2107	Томилолт, зочны зардал	-	3,627,700.00
210702	Дотоод албан томилолт	-	3,627,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	5,073,280.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	3,180,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	93,280.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,966,420.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	297,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	1,669,420.85
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1,239,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	1,239,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,239,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-	178,824,867.18
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-	178,824,867.18

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

0	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	-	338,712,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	21,368,250.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	21,368,250.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	21,368,250.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	18,850,250.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,518,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	317,343,950.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	317,343,950.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	317,343,950.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	-	264,057,532.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	264,057,532.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	262,818,532.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	144,323,890.09
210101	Үндсэн цалин	-	107,780,706.95
210102	Нэмэгдэл	-	14,261,163.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	5,825,995.17
210104	Урамшуулал	-	16,456,024.43
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	18,131,501.66
210201	Тэтгэврийн даатгал	-	13,413,600.54
210202	Тэтгэмжийн даатгал	-	1,242,792.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	990,873.67
210204	Ажилгүйдлийн даатгал	-	225,839.65
210205	Эрүүл мэндийн даатгал	-	2,258,395.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	32,249,205.09
210301	Гэрэл, цахилгаан	-	1,971,310.09
210302	Түлш, халаалт	-	26,663,175.00
210303	Цэвэр, бохир ус	-	3,614,720.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	10,531,030.00
210401	Бичиг хэрэг	-	1,768,300.00
210402	Тээвэр, шатахуун	-	3,195,790.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	31,350.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	953,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	4,582,090.00
2105	Нормативт зардал	-	42,682,676.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	18,198,174.00
210502	Хоол, хүнс	-	23,098,502.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,386,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	5,982,250.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,880,600.00
210604	Урсгал засвар	-	4,101,650.00
2107	Томилолт, зочны зардал	-	3,627,700.00
210702	Дотоод албан томилолт	-	3,627,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	4,993,280.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	3,100,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	93,280.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	297,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	297,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1,239,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	1,239,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,239,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	74,654,667.16
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	16,150,490.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	16,150,490.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	16,150,490.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	16,150,490.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(16,150,490.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	58,504,177.16
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	58,504,177.16

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын	Дахин үнэлгээний	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	178,824,875.18	-	178,824,875.18
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	178,824,875.18	-	178,824,875.18

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	336714700.00	236975389.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	336714700.00	236975389.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	333961000.00	235736389.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	175577600.00	120091615.09
210101	Үндсэн цалин	119497200.00	83548431.95
210102	Нэмэгдэл	33897300.00	14261163.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10890000.00	5825995.17
210104	Урамшуулал	11293100.00	16456024.43
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22134800.00	15281633.66
210201	Тэтгэврийн даатгал	15051600.00	10563732.54
210202	Тэтгэмжийн даатгал	1770800.00	1242792.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	1416600.00	990873.67
210204	Ажилгүйдлийн даатгал	354200.00	225839.65

210205	Эрүүл мэндийн даатгал	3541600.00	2258395.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33800000.00	32249205.09
210301	Гэрэл, цахилгаан	2650000.00	1971310.09
210302	Түлш, халаалт	28000000.00	26663175.00
210303	Цэвэр, бохир ус	3150000.00	3614720.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14237000.00	10531030.00
210401	Бичиг хэрэг	3900000.00	1768300.00
210402	Тээвэр, шатахуун	5150000.00	3195790.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,526,500.00	31,350.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,100,000.00	953,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,560,500.00	4,582,090.00
2105	Нормативт зардал	48,168,000.00	42,682,676.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,918,000.00	18,198,174.00
210502	Хоол, хүнс	24,800,000.00	23,098,502.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,450,000.00	1,386,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,429,600.00	5,982,250.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,750,000.00	1,880,600.00
210602	Тавилга	8,000,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	227,600.00	-
210604	Урсгал засвар	3,452,000.00	4,101,650.00
2107	Томилот, зочны зардал	5,500,000.00	3,627,700.00
210702	Дотоод албан томилолт	5,500,000.00	3,627,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,114,000.00	4,993,280.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,150,000.00	3,100,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	550,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	164,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	150,000.00	93,280.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,100,000.00	1,800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00	297,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,500,000.00	297,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,753,700.00	1,239,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,753,700.00	1,239,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,753,700.00	1,239,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	336,714,700.00	308,102,400.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	336,714,700.00	287,604,150.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	336,714,700.00	287,604,150.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	20,498,250.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	17,980,250.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,518,000.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		58,504,177.16
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22.00	19.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	15.00	13.00
620003	Үйлчлэх ажилтан	6.00	5.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг нь “Уламжлалт анагаах ухааны нотолгоонд суурилсан эмчилгээ үйлчилгээний цар хүрээг өргөжүүлж, тусламж үйлчилгээний чанарыг эрхэмлэн, ёс зүй, харьцаа хандлагыг дээдлэн, үйлчлүүлэгчийн аюулгүй ажиллагааг хангаж, тусламж үйлчилгээг сэтгэл ханамжийн өндөр түвшинд үр дүнтэй хүргэх” гэсэн зорилгын хүрээнд мэргэшсэн боловсон хүчнээр хангагдаж, тэдний ололт амжилтаар дамжуулан дэвшилтэт технологи, техник төхөөрөмжийг эмчилгээ, оношилгоонд нэвтрүүлж, ард иргэдэд шуурхай үйлчилгээ үзүүлдэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоол “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах журам”
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 06 дүгээр тогтоол “Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 178,824.8 мянган төгрөг байна. Тус байгууллага нь 2022 оны 5 дугаар сард “Эмнэлгийн мэргэжлийн

үйл ажиллагаа” явуулах тусгай зөвшөөрөл авч, хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх шинэ хуулийн этгээд болсон байна

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	58,504.1	58,504.1
Авлага	-	-	-
Бараа материал	-	52,461.5	52,461.5
Үндсэн хөрөнгө	-	67,859.1	67,859.1
Нийт хөрөнгө	-	178,824.8	178,824.8
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	-	178,824.8	178,824.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн		178,824.8	178,824.8

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 54,582.9 мянган төгрөгөөр өссөн нь ЭМД-ын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн үлдэгдэл байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 52,461.5 мянган төгрөг болж
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 67,859.1 мянга болж
- Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 178,824.8 мянган төгрөг болсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Эрүүл мэндийн салбарын төсвийн төсөл боловсруулах процесс өөрчлөгдөж ЭМДС-ийн санхүүжилтийг Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн 01, 05 дугаар тогтоолын дагуу хүн амын тоо, насны ангилал, хүйс, хот хоорондын зайнаас хамааруулж нэг иргэнд ноогдох норматив зардал, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг тухайн жилийн тоон үзүүлэлтэд тулгуулан төсвийг 333,961.0 мянган төгрөгөөр баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг ЭМДС-аас санхүүжилт 333,961.0 мянган төгрөгөөр төсөв батлагдсанаас 333,961.0 мянган төсөв батлагдсанаас 280,208.0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулжээ.

Гүйцэтгэлээр ЭМД-ийн сангаас 317,343.9 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 21,368.2 мянга, нийт 338,712.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 58,504.1 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 280,208.0 мянган төгрөг буюу 83.5 хувьтай зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл
/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	333,961.0	278,969.0	54,992	83.5
5	80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал, дэмжлэг		1,239.0	-1239	0
НИЙТ		333,961.0	280,208.0	53,753.0	83.5

Сүхбаатар аймгийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн 2022 оны 5 дугаар сард “Эмнэлгийн мэргэжлийн үйл ажиллагаа” явуулах тусгай зөвшөөрөл авч, хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд болсон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор О.Барчидгүнсэн, гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01/16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 264,137.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 5,282.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1¹, 15.2.3²-т зардлын хэмнэсэн эсэхийг үзэхэд: тээвэр шатахууны зардал 3,195.7 мянга, байр ашиглалтын зардал 32,249.2 мянга төгрөгийг зарцуулсан байна.

Дээрх зардлууд өмнөх оноос нэмэгдсэн учир шалтгааныг авч үзвэл:

- Тээвэр шатахууны зардал: Шатах тослох материалын үнэ өмнөх оноос дунжаар 52.0 хувиар нэмэгдсэн нь гол нөлөөлөл үзүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант оны өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8³ заасныг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг www.shilendans.gov.mn цахим хуудсанд бүрэн гүйцэт мэдээлж байх зөвлөмж өгсөн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Сүхбаатар аймгийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг нь бусад хууль тогтоомжийн хүрээнд асуудал гараагүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 1алдаа зөрчил илэрснээс, алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

5.1 Зөвлөмж

5.1.1 Илрүүлэлт Шилэн дансны цахим системд тайлант онд гарсан өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг байршуулаагүй. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8⁴ заасныг зөрчсөнд зөвлөмж өгөв.

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

² сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

³ бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;

⁴ бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр

Өгсөн зөвлөмж Өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг www.shilendans.gov.mn цахим хуудсанд бүрэн гүйцэт мэдээлж байх
 Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал								
/мянган төгрөгөөр/								
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
www.shilendans.gov.mn цахим хуудсанд хугацаа хоцроож мэдээллэсэн	1	0					1	0
Дүн	1	0					1	0